



ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Өмнөговь, Цогцэлтүй сум, Утас: 7535-5555, 9500-1619
и-мэйл: info@tavantolgoi.mn

2024.04.30 № 1-416
танай -ны № -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Хишиг арвин индустрал” ХХК-иас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 1/123 тоот албан бичигтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Манай компаниас 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан “Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/” ТТХК/20240101011 дугаар бүхий тендерийн баримт бичгээс доорх асуултад тодруулга хүссэн байна.

- “Санхүүгийн түрээсийн гэрээ болон фидуцийн гэрээтэй техник тоног төхөөрөмжүүдийг өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмж гэж үзэх эсэхийг тодруулж өгнө үү” гэсэн дээр тодруулга өгөхөд Санхүүгийн түрээсийн гэрээ болон фидуцийн гэрээтэй техник тоног төхөөрөмжүүдийг өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмж гэж үзэхгүй болно.
- “Санхүүгийн түрээсийн гэрээ болон фидуцийн гэрээтэй бол урьдчилгаа төлбөр төлсөн баримт шаардлагатай юу?” гэсэн дээр тодруулга өгөхөд Санхүүгийн түрээсийн гэрээ болон фидуцийн гэрээтэй техник тоног төхөөрөмжүүдийг өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмж гэж үзэхгүй учраас урьдчилгаа төлбөр төлсөн баримт шаардлагагүй болно.
- “Тосолгооны машин, Хог хаягдал тээвэрлэх машин, Автокран, Дугуй өргөгч, Түлшний машин, Галын машин, Түргэн тусламжийн машин, Гэрэлтүүлэгч цамхаг, Усны насос зэрэг бусад туслах техникийдийн үйлдвэрлэгчийн брошурыг тендерийн материалд хавсаргах шаардлагатай эсэхийг тодруулж өгнө үү.” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “Үйлдвэрлэгчээс гаргасан техникийн үзүүлэлт бүхий каталоги танилцуулга ирүүлнэ.” гэж зааснаар хавсаргаж ирүүлэх шаардлагатай болно.
- “Геофизик болон газар зохион байгууллагч гэсэн мэргэжлүүдийг геологич албан тушаалтай дүйцэх мэргэжил гэж үзэн тендерт санал болох эсэхийг тодруулж өгнө үү.” гэсэн дээр тодруулга өгөхөд тус геофизик болон газар зохион байгууллагч гэсэн мэргэжлүүдийг геологич албан тушаалтай дүйцүүлэн тооцохгүй болно.
- “Үнийн тохируулга хэсэгт Дизель түлшний үнийн өсөлт, бууралт нь нэмэх, хасах 20 хувь үед үнийн тохируулга хийнэ болон Ашигт малтмал, газрын тосны газрын хил үнэ 10 хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохирулна. гэж заасан байна. Уг хоёр заалтын алыг нь баримтлах талаар тодруулга өгнө үү.” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн

ТШЗ 21.6-д “Тендер зарласан өдрийн Ашигт малтмал, газрын тосны газраас зарласан Дизель түлшний үнийн өсөлт, бууралт нь нэмэх, хасах 20 хувь үед үнийн тохируулга хийнэ. Мөн Ашигт малтмал, газрын тосны газрын хил үнэ 10 хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна.“ гэж заасны аль нэг нөгцөл байдал үүссэнээс шалтгаалж хэрэглэхийг ойлгож болно.

6. “Дотоодын давуу эрх тооцох эсэхийг тодруулж өгнө үү” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн Д. Хянан үзэх, үнэлэх хэсэгт “Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Ашиглахгүй” гэж заасны дагуу дотоодын давуу эрх тооцохгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ч.ГҮНЖДАГВА